

# Уур амьсгалын өөрчлөлтөд уул уурхайн салбарын дасан зохицох арга зам

## Канад улсын жишээ

Канадын Байгалийн нөөцийн яамны  
Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө, дасан  
зохицлын асуудал хариуцсан газар

Памела Кертланд



Natural Resources  
Canada

Ressources naturelles  
Canada

2019 оны 1 дүгээр сарын 24

Canada

## Канад улсад

- Канад улсад уур амьсгалын өөрчлөлтийн эрсдлийн талаарх ойлголт түгээмэл ойлголтуудын нэг юм.
- Дасан зохицох арга хэмжээ нь цаг агаарын онц үзэгдэлтэй ихээхэн холбоотой. (жишээ нь: үер ус, ой хээрийн түймэр г.м)
- Мэдээ мэдээлэл, арга хэрэгсэл, сургалтын хэрэгцээ их байдаг.
- Салбар дундын, бүс нутгийн хамтын ажиллагаа, түүнийг хэрэгжүүлэхдээ тодорхой зарчимтай байх нь маш чухал асуудал.



Natural Resources  
Canada

Ressources naturelles  
Canada

Canada

## Дасан зохицох платформ: Хамтын ажиллагааг өргөжүүлэх

**Мэргэжлийн байгууллагууд**

**Бүс, дүүрэг**

**Үндэсний хэмжээн дэх салбарын байгууллагуудын холбоод**

**Холбооны ЗГ-ын яамд, тамгын газар, агентлагууд**

- Мэдлэг, чадвар болон нөөцийг нэгтгэсэн бодлого
- Бүсийн захиргаа болон салбарын компаниуд уур амьсгалын өөрчлөлтийн талаарх ойлголттой болох, түүнчлэн дасан зохицох шийдвэр гаргахад хэрэгцээтэй мэдээлэл, арга хэрэгсэлтэй болоход анхаарах
- Хамрах хүрээг өргөжүүлэх
  - + аж үйлдвэр болон санхүүгийн салбар
  - + холбооны яам, тамгын газар
- Оролцогч байгууллагууд өөр өөрсдийн нөөц, бололцоо, тэргүүлэх чиглэл, үүрэг хариуцлага зэргээ тодорхойлох

Natural Resources Canada / Ressources naturelles Canada

## Дасан зохицох платформ хэрхэн ажилладаг вэ?

Тэргүүлэх чиглэлийн хүрээнд авах арга хэмжээг тодорхойлох

**Дасан зохицох нэгдсэн бодлого\***

Удирдлагын түвшний төлөөлөл:

- Мүжийн/Бүс нутгийн хэмжээний орон нутгийн засаг захиргаа
- Холбооны яамд, тамгын газар
- Мэргэжлийн байгууллагууд
- Салбарын байгууллагуудын холбоод

**Дасан зохицох бодлогын ажлын хэсэг**

**Уул уурхай\***

**Хөдөө аж ахуй**

**Биологийн олон янз байдал**

**Уур амьсгал**

**Эрчим хүч**

**Ой**

**Эдийн засаг**

**Барилга, дэд бүтэц**

**Эргийн удирдлага**

**Явцын хэмжилт**

Шийдвэр гаргалтыг дэмжих шинэ бүтээгдэхүүн, бодлого, арга зам бий болгохын тулд салбарын мэргэжлийн хүмүүс болон эцсийн хэрэглэгчдийн хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх

Natural Resources Canada / Ressources naturelles Canada

## Уул уурхайн ажлын хэсэг

- Холбооны болон орон нутгийн засаг захиргаа, салбарын аж ахуй нэгж, их дээд сургууль, төрийн бус байгууллагуудаас бүрдсэн гишүүдтэй
- 5 жилийн хугацаатай:
  - Мэдээ мэдээлэл, үйл ажиллагааг үнэлэх – шинжлэх ухааны судалгаа, баримт бичгийг хянах, шийдвэр гаргагчдыг сонгон шалгаруулах
  - Ажлын төлөвлөгөө гаргах
  - Шаардлагатай төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх
  - Үр дүнг мэдээлэх, танилцуулах
  - Ажлын явц, арга барилыг үнэлэх
- Эдийн засаг, эрчим хүч, биологийн олон янз байдал зэрэг салбар, сэдвүүдийн хүрээнд мэдлэг, мэдээллийг түгээх арга замыг тодорхойлох



Natural Resources  
Canada

Ressources naturelles  
Canada

Canada

## Дасан зохицлын жишиг судалгаа



- Уул уурхайн компаниудын өнөөг хүртэл авч хэрэгжүүлж буй арга хэмжээг танилцуулах
- Авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд нь гол төлөв байгалийн онц үзэгдэлд авсан хариу арга хэмжээ байсан хэдий ч зарим нь ирээдүйн төлөв байдлыг харгалзан үзсэн асуудлыг хөндсөн




Natural Resources  
Canada

Ressources naturelles  
Canada


Canada

7


## Бодлогыг хэрэгжүүлэх хэрэгслүүд ба тулгарч буй саад бэрхшээлүүд




- Дасан зохицлын асуудлыг бодлогоор дэмжсэн тохиолдол ховор
- Өөрчлөлтийг бодлогоосоо илүүтэйгээр үйл явц нь сааруулдаг байж болох юм
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ – уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудлыг шинээр хэрэгжүүлж буй төслүүдэд тусгасан байдаг ч зааварчилгаа нь уялдаа холбоо муутай байдаг.



Natural Resources  
Canada




Ressources naturelles  
Canada




8

## Эдийн засгийн жишиг судалгаа




Гол үр дүн:


- Өртөг, үр ашигтай холбоотой шийдлүүд мөн аливаа арга хэмжээг аль мөчид авч хэрэгжүүлэх нь зүйтэй эсэх нь бүгд тухайн талбайгаас хамааралтай.
- Өнөө үед хаягдлын цөөрмийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, усны менежментийн тогтолцоог сайжруулах, тоосны хаалт барих зэрэг чиглэлд хөрөнгө оруулалт хийх нь үр ашигтай.
- Зарим арга хэмжээг ирээдүйд хэрэгжүүлэх нь илүү зардал хэмнэх боломжийг бүрдүүлдэг.
- Бизнесийг хөгжүүлэхэд үнэтэй мэдээлэл болдог.
- Эрсдлийн үнэлгээ хийснээр эдийн засгийн судалгааг үндэслэл сайтай хийх боломжийг нэмэгдүүлдэг.



Natural Resources  
Canada



Ressources naturelles  
Canada



## 2016 оны байдлаар

- Салбарын компаниуд, засгийн газар, олон нийтийн эрсдлийн талаарх ойлголт нэмэгдсэн
- Дэлхий нийтээрээ санхүүгийн эрсдэл болоод түүнд авах хариу арга хэмжээнд илүү анхаарал хандуулах болсон
- Эрсдлийг үнэлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох аргачлалын загвар шийдэл гаргах инженерүүдийн чадавхийг нэмэгдүүлсэн
- Шаардлагатай стратеги боловсруулж, эрсдлийг даван туулах шинэ арга замуудыг тодорхойлсон

### Ажлын төлөвлөгөө:

- Дасан зохицлын талаарх ойлголтыг нэмэгдүүлж, чадавхийг бэхжүүлэх
- Шийдвэр гаргалтад дасан зохицлын асуудлыг тусгах тэргүүн туршлагыг нэвтрүүлэх
- Орхигдсон болон хаягдсан уурхайн асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой эрсдлийн үнэлгээ хийх

### Бусад боломжууд:

- Эрдэм шинжилгээний судалгаа, шинжилгээ болон үйл ажиллагаатай уялдуулах

## Уурхайн дэд бүтцийг урт хугацааны уур амьсгалын эрсдлийн талаас нь загварчлах

- Юконы засгийн газар – Эрчим хүч, уурхай, нөөц
- Уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч, бодлого боловсруулагчдад зориулсан, мөн кварцын уурхайн төслүүдэд илүү анхаарал хандуулсан шинэ удирдамж (техникийн бичиг баримт)
- Дараах зүйлсийг багтаасан байх: загварт тавигдах минимум шалгуур үзүүлэлт, загварчлал, мониторинг, дасан зохицлын менежментийн шаардлагууд
- Төсөл дуусах хугацаа: 2020 оны 11 дүгээр сар

## Уул уурхайн салбарын уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл болон дасан зохицлын шилдэг туршлага

- **Канадын Уул уурхайн ассоциаци** удирдлагаар хангадаг
- Канадын уул уурхайн салбарт (салбарын компаниуд) зориулан Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл болон дасан зохицлын шилдэг туршлагын талаарх удирдамж баримт бичгүүд боловсруулдаг
- Арга аргачлал, мэдээллийн эх үүсвэр, шаардлагатай бичиг баримтжуулалтын талаар тодорхой чиглэл өгдөг
- 2020 оны 11 дүгээр сард дуусах



Natural Resources  
Canada

Ressources naturelles  
Canada

Canada

## Орхигдсон, хаягдсан уурхайд хийх Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдлийн үнэлгээ (2 төсөл)



1. Ньюфаундланд ба Лабрадор: Эдгээр уурхайнуудад учирч болзошгүй эрсдэл болон хариуцлагыг тооцоолох үүднээс уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг харгалзан үзэж, нэмж оруулах
2. Онтарио, Юкон, Хойд бүсийн нутаг дэвсгэрт байрлах 3 уурхайд хийх эрсдлийн үнэлгээнд илүү анхаарал хандуулах юм.
  - 2020 оны 11 дүгээр сард дуусах



Natural Resources  
Canada

Ressources naturelles  
Canada

Canada

## Дүгнэлт

- Дараах асуудлуудад ахиц дэвшил гарсан. Үүнд:
  - Салбарын оролцоо
  - Авах арга хэмжээний хүрээн дэх бодлогын орчны талаарх ойлголт
  - Үйл ажиллагааны зардал, үр ашгийн дүн шинжилгээ
- Шилдэг туршлага, орхигдсон уурхайн эрсдлийн дүн шинжилгээ, нөхөн сэргээлтийн ажилд учирч болох эрсдэл зэрэгт анхааран ажиллаж байна.
- Асуултууд:
  - Бид урт хугацаанд гарч болох асуудлыг цогцоор нь харж чадаж байна уу?
  - Үнэ цэнийн болон нийлүүлэлтийн гинжин хэлхээний дүн шинжилгээ
  - Салбар хоорондын эрсдэл, боломж (жишээ нь: барилгын стандарт г.м)

## БАЯРЛАЛАА